

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-4

- 
1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хоёр дахь хэлэлцүүлэг**/ 3-4
  2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/ 4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 09 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Н.Учрал, Ж.Чинбүрэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Ганибал, Ц.Сэргэлэн.

**Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Эрдэнэбат, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 0  
Бүгд: 6  
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

*Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Эрдэнэбат, референт П.Болорцэцэг нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 06 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 15 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 09 минут.

### **ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Э.Батиугар:** Байнгын хорооны нийт гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

28 дугаар тойрог Э.Батиугар, 26 дугаар тойрог Ганхуяг, 29 дүгээр тойрог Доржханд, 18 дугаар тойрог Идэрбат, 22 дугаар тойрог Саранчимэг, 13 дугаар тойрог Ундрам. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, Монгол Улсын Засгийн газар, 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газар, 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга. Хэлэлцэх асуудалдаа оръё.

### **Нэгдүгээр асуудал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцье.**

Ажлын хэсэг ирчихсэн байгаа юу? Ажлын хэсгийг танилцуулъя. Хишигээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нинжбатын Ууганбаатар МУИС-ийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн Эдийн засгийн танхимын дэд профессор,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-т Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргана.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан.

Хууль санаачлагчдаас асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах талаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь

хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцэж дууслаа. Хоёр дахь асуудалдаа оръё.

Хурлын гишүүн Идэрбат гишүүн танилцуулна.

10.13 цаг

**Хоёр дахь асуудал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хорооны хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдолтой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Хуулийн төслийн хоёр дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их

Гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа. Энэ өдрийн өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

10.15 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР